

94. Есүс - Миний алдагдсан, ганцаардмал хүмүүсээ Над руу ир...

Хуучин ачаагаа орхи ... гэж дууддаг.

Долдугаар сарын 15, 2015 _ Эгч Кларид Есүсээс ирсэн үгс

Есүс : Минии зорилго бол надад хайртай хүмүүсийн амьдралд муу муухай зүйлийг хүргэхгүй байх явдал юм. Би хэзээ ч хэн нэгнийг орхиогүй. Хүмүүс намайг орхисон. Тэдний залбирал тэдний өөрсдийн хүссэнээр л болохгүй бол тэд надад итгэддэггүй. Энэ шалтгаанаар маш олон хүн Надаас холдон одсон. Тэд миний хязгааргүй мэргэн ухаан болон Миний тэднийг яаж хайрлаж байгааг төсөөлөх ч үгүй. Харин ч тэд сатан буруутай байсан ч, тэдний амьдралд тохиолдсон буруу зүйл болгонд Намайг буруутгадаг. Тэд над руу хандаж залбирвал бүх зүйл өөр байх байсан, гэвч тэдний юу хүсч байгааг, ямар замаар явж ямар зам мөр түүлахыг Би мэдэж байгаа учраас тэдэнд хариулж чаддаггүй.

Цаг хугацааны явцад дүр исгэсэн эсвэл тийм ч сайнгүй Христэд итгэгчидийг дагаснаар бурхангүй үзэлтэнүүд гарч ирэн, үл мэдэгдэхүйцээр буруу үйлдэлүүд хийсээр байна. Тэд Миний хүүхдүүдэд ханддагтай адил жишигийг бурханд итгэдэггүй ах дүүстэйгээ хандаасай гэж Би хүсдэг. Би тэдэнд " Миний хүүхдүүд чамаас илүү төгс сайн биш, гол нь тэд УУЧЛАГДСАН" гэж хэлж чаддаг ч болоосой. Миний тусламжтайгаар олон олон хүмүүс өөрчлөгдөхийг оролдон хичээцгээж байна. Та Христэд итгэгчидийн амьдралын ард яг юу болж байдагыг үргэлж харж байгаагүй. Мөн намайг тэднийг олж автал тэд ямар байсныг ч мэдэхгүй.

Клари : Эзээн, би одоо өөрийнхөө тухай бодож байна. Хмм, би хэзээ ч сайн байгаагүй, хэзээ ч. Амин хувиа бодсон, бардам, материаллаг бүхэнд гүн шунасан, хүмүүсийн анхааралын төвд байж анхааралыг нь татах гэсэн, найз нөхөдийн баттай холбоо тогтоох чадваргүй, хайрлаж хайрлагдаж чадахгүй тийм л байсан. Гэвч энэ бүгд өөрчлөгдсөн. Гэхдээ би төгс төгөлдөр хүн биш, одоо хүртэл надад бэрхшээл тулгардаг, гэхдээ урьдын бэрхшээлүүдтэй адилгүй.

Есүс: Хайр чиний амьдралд орж ирсэн. Чиний үргэлж төсөөлж мөрөөдөж байсан шиг цэвэр ариун, үнэнч нөхөрлөлийн хайр. Үнэхээр би ирж, Би хэн бэ? , чи Миний хувьд хэн бэ? гэдгийг чамд илэрхийлсэн. Үнэхээр чи бол миний хувьд онцгой, үнэхээр онцгой. Хэн ч чамд ингэж хандаж, чи ингэж өөр бусдаар өөрийгөө ойлгуулж байгаагүй. Хэзээ ч чи Би чиний зүрх сэтгэлд нэвтгэн орох хүртэл амьдралдаа ийм их амар тайванг мэдэрч үзээгүй. Чи ямар ч эргэлзээгүйгээр Би бол Бурхан гэдгийг мэдэж, чамайг удирдан чиглүүлж, хайрлан хамгаалж, Миний Хаант Төрийн тухай заалгаж, надтай нөхөрлөхийг юу юунаас дээр гэдгийг мэдэх болно.

Чиний сүмийн амьдрал бусад газрын амьдралаас дээрдэх юмгүй байсан. Гэвч чамд нэгэн зүйл байна, энэ нь Надтай тогтоосон хувийн холбоо юм. Чи Миний гадуур хүрэмний эмжээрт хүрч, өдрөөс өдөрт тохиолдох муу зүйлсээс, бүр сүм дээрх буруу зүйлсээс аврагдана.

Чи хар даа, Бурхан шашин шүтлэг хоёрын хооронд адил төстэй юм байхгүй. Шашин бол хүмүүсийг Бурхан руу ойртуулах гэсэн хүний хөгжүүлсэн систем, харин Би чамайг ямар ч дүрэм журамгүйгээр, тэр бүү хэл Миний нэрийн тухай мэдлэггүйгээр хүлээн авдаг. Энд олон хүмүүс Намайг зүрх сэтгэлээсээ мэдэрч, миний асуусан бүрийг хийдэг. Тэгээд ургац хураах цаг нь болохоор Би тэдэнд өөрийгөө илчлэх болно.

" Түүнээс гадна, зарим хүмүүс маш хүнд хэцүү амьдралд нухчуулсаар байгаа болохоор тэдэнд хайрлах, хайрлагдах тухай итгэл ч алга. Би тэднийг Өөрийхөө хайраар гайхшруулах ёстой ба хэзээ ч санаанд нь оромгүй үед нь Өөрийн төгс төгөлдөр, хязгааргүй хайраараа бялхаах болно. "

Маш олон хүмүүс Намайг тэдний амьдралд тохиолдсон бүх л буруу зүйлд буруутгадаг. Яагаад гэвэл тэд өөрсдийнхөө гэм нүгэлээс ангижрахыг хүсдэггүй. Хааяа тэд миний дуу хоолойг зүрх сэтгэлдээ сонсдог боловч энэ ертөнц болон түүний юмсад автагдан хэт оройтлоо үл тоомсорлон амьдардаг.

Би тэдний амьдарлыг илаашруулахаар хүлээсээр, үргэлж хүлээсээр дуудсаар байдаг. Гэвч, тэд бүр ядаж өөрсдийнхөө гэм нүгэлийг орхиж, Миний хайрыг хүлээн авахад бэлэн байх ёстой. Тэдний махан биесийн зугаа цэнгэл нь надаас ч илүү бодогдож, Би тэднийг хөгшрөөд сул дорой болох хүртэл нь хүлээх хэрэгтэй болдог.

Гэсэн хэдий ч, тэд уй гашуу зовлонгийнхоо үед ч Намайг сонсож дагах баталгаа байхгүй. Тиймээс би тэдэнд хүрч болох үеийг буюу тэднийг асрамжийн газраа насан эцэслэхийг нь хүлээж, гэрт нь буцаан авчирна.

"Өө, ямар их харамсалтай вэ? Хэн нэгэн нь миний хайраас татгалзаж, энэ ертөнцийн хоосон руу эргэн одох нь. Тэд өөрсдийгөө зөвтгөн тэр бодолдоо итгэж гэмших сэтгэлгүйгээр орь ганцаар орхигддог. Тэд бүх л зүйлд бусдыг буруутгаж өөрөө гэмгүй хохирогч болж, буруутан нь Бурхан болдог.

Клари, Би чамайг хайрлагдмааргүй нэгнийг хайрлахыг хүсч байна. Гарч Надаас татгалзсан нэгний замаар яв. Миний гар, Миний хөл, Миний ам, Миний чих бол. Бүр ядаж энэ эцсийн өдрүүдэд, Би тэднийг ятгамаар байна. Тэд тийм эрхгүй ч, Би тэдэнд өөрийнхөө сайхан сэтгэлийг дахин сануулмаар байна. Маш олон удаа тэд татгалзсан ч, бүр хамгийн сүүлчийн удаад эргэж, өөрсдийн нүгэлийг гүн гүнзгий ойлгон нулимс асгаруулан, тэд Надад ямар их онцгой, бүр хэмжээлшгүйгээр онцгой болохоо мэдэрнэ. Би ямар их тарчлал, эрүү шүүлтийг даван түүлж тэднийг надтай хамт Диваажинд үүрд амьдруулахаар болсон билээ. Би тэднийг эрхэмлэн дээдэлж, хайрлан энэрч, элэгэндээ нааж, дахин хэзээ ч хагацан салахгүй.

Эдгээр өдрүүдэд маш олон хүмүүс энэ замаар аврагдана. Тийм учраас Би та нараас хайрлагдмааргүй нэгнийг хайрла гэж дахин дахин сануулсаар байна. Тэд бол бүхнээс илүү дорой, ялангуяа эд хөрөнгөд автагсад.

Клари: Эзээн, Та Израйлчуудыг удирдан аймшигт зүйлс хийснээрээ үргэлж буруутгагддаг. Зарим хүмүүс Яагаад Бурхан үүнийг хийв? Тэр юу хийснийг, эр эмгүй хүүхэд нялхасгүй бүгдийг нь арчин хаях зарлиг өгсөнийг олж мэдэхийг хүсдэг. Хүмүүс үүнийг ойлгодоггүй учираас тэд Таныг харгис хэрцгий, аймшигийн Бурхан гэдэг.

Есүс: Тэд Молохд өргөл болгон, улайссан төмөр зууханд шарагдан зүрх зүсэм хашгирах нялхасын аймшигт дууг сонсоогүй. Тэд мөн амьтан мал ч тэсвэрлэшгүй, амьтантай явалдаж байсан хүмүүсийн завхарлыг ч олж хараагүй. Чөтгөрүүдтэй нөгцөн, чөтгөр шуламын хүчинд автан, мүү ёр, хорон санаагаар дүүрснийг ч бас олж хараагүй.

Яагаад миний хүмүүс амьтай болгоныг устгасныг олон мянган жилийн дараа ч маш багыг ойлгоно. Хэдий тийм боловч , Миний Үг тайлбараар дутаагүй. Тэдний гэмт явдалууд засаж залруулхаас аль хэдийнэ өнгөрсөн байлаа. Харин одоо та бүхэн Ноагийн өдөрүүдэд ойртож байна. Ноагийн өдрүүдэд яг ийм юм болж байсан. Тиймээ, бүх л гажуудал, гэмт явдлууд хуулиар зөвшөөрөгдөх болно. Нялх балчир хүүхдүүдийг таалах, амьтан малтай бэлэгийн харьцаанд орох, эр хүн эр хүнтэйгээ, эм хүн эм хүнтэйгээ явалдах мэт энэ бүгдийн цаг нь ирж байна. Тун удахгүй садар самуун киноноос илүү бүх л жигшүүртэй зүйлийг хуулиар батлан гарын үсэг зурна. Цаашилбал, эдгээр зугаа цэнгэл нь тэдний эрх чөлөө, хүний эрх мэт болно.

Би та нарыг дуудаж байна. Миний Хүүхдүүд ээ, Миний дур зоргоороо авирлагчид аа. Өнчрөл хагацлаасаа ангижир. Ядарч зовсон, хүнд зовлон туулагсад аа ир, Над руу ир. Чи амар амгаланг олж, зүрх сэтгэлдээ хязгааргүй их хайрыг мэдрэх болно. Би чамаас хэзээ ч үрвахгүй. Би чамайг хэзээ ч орхихгүй, харин ч чиний амьдрал гэгээлэг болж, улам их гэрэлтэх болно. Би хүдлаа ярих хэрэгтэй болдог хүн биш. Би та бүхэнд сайн сайхан бүхнийг нөөцөлсөн. Надад тө нарт өгөх та нарын хамгийн дуртай хийхийг хүсдэг авьяас бэлэгүүд, үр чадварууд байна. Хэн энэ бүхнийг та бүхэнд хүсэх вэ? Одоо та нарын амьдралд элбэг дэлбэг байдал, аз жаргал авчирахыг хүсэж байна.

"Чиний нүгэл чамд зөвхөн сэтгэлийн шаналал, гансарлыг л авчирна. Одоо хуучин хүнд хүчир ачаагаа орхиж өөрчлөгдөх цаг нь болсон. Хуучин хүнээ сольж шив шинээр дахин төрж эхэл. (baptism)"

"Над руу ир, Миний алдагдсан хүмүүсээ, Би та нарыг дуудаж байна. Би та нарыг хэвлийдээ дахин төрж байгаад \ Бурханы энэрэлд орж ирж байгаад\ талархалын болон баяр хөөрийн дууг дуулж угтан, элгэндээ тэврэн авах болно. Тиймээ, би чамайг хамгийн сайн даавуугаар хийсэн хувцсаар гоёж, хуруунд чинь бөгж зүүлгэн, хөлд чинь углааш өмсгөж, бид нэг юм шиг хамтдаа алхах болно.

Чи бусдыг гомдоож болон бусдад гомдож, ядарч туйлдснаа зөвхөн Надад хэл. ямар их нүгэл хийснээ санан уучилалт гуй. Тэгээд хамаг амьдарлаа надад даатган Миний өршөөл уучлалыг асуу. Би чамайг баясгах болно. Би чамайг удирдан чиглүүлэх болно. Би чамайг хэзээ ч орхихгүй. Би чамайг үүрдийн аз жаргал руу, Диваажин дахь Эцэгийнхээ Хаант Төр рүү мөнхөд амьдруулахаар гардуулан өгөх болно. "

"Есүс, намайг өршөөгөөч, би таньд амьдралаа өгөө. (Есүсийн хуулийн дагуу амьдрах гэсэн утгатай)

Намайг удирдан, надад заагаач, хэзээ ч надаас бүү холдооч" гэж чин сэтгэлээсээ залбирна уу.